



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 28 өдөр

Дугаар А/433

Мөрөн сум

Гэрээ байгуулах эрх олгож, захиалагчийн  
төлөөлөгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 30 дугаар зүйлийн 30.1, 30.4, 39 дүгээр зүйлийн 39.1, 39.3, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2.6, Засгийн газрын 2017 оны "Захиалагчийн дүрэм батлах тухай" 170 дугаар тогтоол, Засгийн газрын 2023 оны "Журам батлах тухай" 278 дугаар тогтоол, Сангийн сайдын 2023 оны "Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг-2024" А/259 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны "Байгууллагуудын хэрэгжүүлэх чиг үүрэг батлах тухай" А/95 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн замын сангийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр батлагдсан Шивэрт, Бумбатын давааны зам засвар, арчлалт /Шинэ-Идэр сум/ төсөл арга хэмжээний ажлыг гүйцэтгэгч сонгох ХӨАХААГ/20240201101/ дугаартай 144,275,423 (Нэг зуун дөчин дөрвөн сая хоёр зуун далан таван мянга дөрвөн зуун хорин гурван) төгрөгийн үнийн санал ирүүлсэн "Гоо Жим" ХХК-ийн тендерийг зөвшөөрч, тус компанитай гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсүгэй.

2. "Гоо Жим" ХХК-тай гэрээтэй холбоотой асуудлаар захиалагчийг төлөөлж харилцах, холбогдох шийдвэрийг гаргах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, ажлын үе шатны хяналт хэрэгжүүлэх, зураг төслийг хүлээн авах, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнэх чиг үүрэг бүхий захиалагчийн төлөөлөгч, ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Захиалагчийн төлөөлөгч:

Б.Оюунтуяа

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө  
оруулалтын хэлтсийн дарга)

Ажлын хэсгийн гишүүд:

Б.Мөнхзул

(Аймгийн Орон нутгийн өмчийн газрын  
өмчийн удирдлага, зохицуулалт  
хариуцсан мэргэжилтэн)

Э.Наранчимэг

(Хөвсгөл барилга захиалагчийн төвийн  
автозамын хяналтын инженер)  
("Гоо Жим" ХХК-ийн захирал)

Д.Гоориймаа

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Д.Сандагдорж

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө  
оруулалтын хэлтсийн Дэд бүтцийн  
бодлого үйл ажиллагааг зохион  
байгуулах мэргэжилтэн)

3. Аймгийн замын сангийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр батлагдсан Шивэрт, Бумбатын давааны зам засвар, арчлалт /Шинэ-Идэр сум/ төсөл арга хэмжээний ажлын

0712011300



гүйцэтгэгч сонгох гэрээнд заасан захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх, ажлын гүйцэтгэлд үе шатанд хийх захиалагчийн хяналтыг "Гоо Жим" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх, уг гэрээг дүгнэх, ил далд ажлын акт, хатуу хучилттай авто замын гүйцэтгэлийг тус тус баталгаажуулах, авто замын ашиглалтад оруулахад шаардлагатай баримт бичгийг бэлтгэж аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт хүргүүлэх, гэрээ болон гэрээний хэрэгжилтийн мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, хөрөнгө оруулалтын үр ашгийг үнэлэх цогц системд тус тус нийтлэх, захиалагчийн төлөөлөгчийн чиг үүрэг хэрэгжүүлсэн ажлын үр дүнгийн тайлан авто замын ажлын гэрээний хэрэгжилттэй холбоотой баримт бичгийг архивын нэгж болгон худалдан авах ажиллагааны газрын архивт шилжүүлэх зэрэг үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулахыг ажлын хэсэг (Б.Оюунтуяа)-д, захиалагч, тендерт оролцогч (тухайн тендерт оролцсон нийт оролцогч)-ийн тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг зохион байгуулсан баримт бичиг, гэрээт ажлын үе шатны хяналтыг хийж, баталгаажуулсан техник хяналтын нэгдсэн дүгнэлт, зохиогчийн дүгнэлт, авто замын ашиглалтад хүлээн авсан шийдвэр, санхүүжилтийн гүйцэтгэл зэрэг баримт бичгийг цахим болон бичгийн хэлбэрээр архивлан Худалдан авах ажиллагааны газрын архивт шилжүүлэхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Д.Төмөр)-д тус тус даалгасугай.

4. Шивэрт, Бумбатын давааны зам засвар, арчлалт /Шинэ-Идэр сум/ гүйцэтгэгч сонгоход хэрэгжүүлэх шаардлагатай зардлыг гэрээний дагуу "Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв" ОНӨААТҮГ-т Шивэрт, Бумбатын давааны зам засвар, арчлалт /Шинэ-Идэр сум/ төсөл арга хэмжээний ажлыг ашиглалтад хүлээн авах ажиллагаатай холбогдон гарах зардлыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт шилжүүлэхийг Худалдан авах ажиллагааны газар (Б.Должинсорогдог)-т тус тус зөвшөөрсүгэй

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга (Б.Должинсорогдог)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ